

2020 ОНЫ IV УЛИРЛЫН
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ ТАЙЛАН

2020.12.23

Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын “Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67-р тогтоолыг мөрдлөг болгон шийдвэрлэж, иргэдээс амаар, бичгээр, нээлттэй утас 7059106, 70593951 утсаар болон цахим хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг тухай бүр мэдээлэн ажиллаж байна.

2020 оны IV улиралд иргэдээс нийт 44 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 6 хүсэлт, 2 гомдол, 33 өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэлээ. Харин хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл байхгүй, шийдвэрлэх хугацаа болоогүй буюу судлагдаж, хянагдах шатандаа явагдаж буй 3 өргөдөл байна.

Өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээж авах ил тод байдлыг хангаж тасаг нэгжүүдэд санал хүсэлтийн хайрцаг байрлуулж, хайрцгаар өргөдөл, гомдол ирээгүй байна. 2020 оны 1 сараас эхлэн өргөдлийг цахим бүртгэлд бүртгэн сан үүсгэн тогтмолжуулсан нь өргөдөл, гомдлын агуулгын ангилалт сайжирсаны зэрэгцээ, хаана, хэнд, шийдвэрлэлт аль шатандаа байгааг хянахад боломж бүрдсэн. Шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдолд бүртгэл хөтлөлтийн картыг хөтөлсөн, картанд хариуцсан эзний гарын үсгийг зуруулж баримтжуулж хэвшсэн.

Хүсэлтийн дагуу хариу арга хэмжээ авсан байдал.

- Хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдлийг хүлээн авч ажлын зохицуулалт хийлгэж чөлөө хүссэн 22 эмнэлгийн ажилтанд 1-7 хүртэлх хоногийн чөлөөг олгож нийгмийн болон хувийн асуудлыг нь шийдвэрлүүлсэн. Нийт өргөдлийн 50%-ийг ажлаас чөлөө хүсэж нийгмийн асуудлаа шийдвэрлэхийг өргөдөл эзэлж байна.
- Ажилд орохыг хүссэн 5 иргэний өргөдлийг хүлээн авч судлан бүртгэсэн. Тэтгэвэрээ тогтоолгоод эргэж ажиллахыг хүссэн 3 эмнэлгийн ажилтантай хөдөлмөрийн гэрээг хугацаатай байгуулж ажлын байранд авч ажиллуулсан.

- Сул ажлын байрны зарын дагуу хоол үйлдвэрлэлийн газарт бэлтгэгчийн ажлын байранд 2 ажилтан орохыг хүсэж өргөдөл ирүүлснээс 1 ажилтан буцаж ирээгүй. 1 ажилтан туршилтын хугацаанд ажиллаж байна.
- Ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн 5 ажилтныг хүсэлтийн дагуу ажлаас чөлөөлж хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон.
- Эрүүл мэндийн газрын ахмадууд түлшний мөнгөн тусламж үзүүлэхийг хүссэн 3 хүсэлт, түрээсийн үйл ажиллагаатай холбоотой 1 хүсэлтийг шийдвэрлэсэн байна.
- Мэргэжлийн үйл ажиллагаа сунгуулахыг хүссэн 1 бага эмчийн хүсэлтийг авч шийдвэрлэсэн.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, эмийн сангийн үйл ажиллагаатай холбоотой 2 өргөдөл, гомдлыг хугацаанд шийдвэрлэсэн байна.

Эмчилгээ үйлчилгээний талаар ирүүлсэн гомдлыг шийдвэрлэсэн байдал.

- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба гомдлын мөрөөр судлахад 2020 оны 11 дүгээр сарын 11 –нд түргэн тусламж очиж иргэнд тусламж үзүүлсэн бөгөөд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай гэсэн боловч иргэн эмнэлэгт хэвтэхээс татгалзсан, 2020 оны 12 дугаар сарын 13-нд дахин дуудлага өгч очиход нас барсан байсан байна. Дуудлагаар очсон эмч эмнэлэгт хэвтүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зайлшгүй шаардлагатайг үйлчлүүлэгчид ойлгуулаагүй, татгалзсан тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээнээс татгалзсан зөвшөөрөл аваагүй байна. Иймд түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах, чанарын хяналт тавьж хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах, холбогдох эмч нартаа хариуцлага тооцохыг эмнэлгийн удирдлагад үүрэг болголоо.
- 2020 оны 11 дүгээр сарын 01-нд батлагдан гарсан Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлттэй олгох жагсаалтад 43 нэр төрлийн эмийн үнийн дээд хязгаар, эм ханган нийлүүлэх байгууллагаас авдаг бөөний үнээс бага үнээр тогтоогдсон байсан тул эмийн сан 43 иргэдэд үйлчлэх боломжгүй бэрхшээл гарсан. Иймд Эрүүл мэндийн газраас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт эмийн сангаас эмийн үнийн хөнгөлөлттэй жороор үйлчлэх боломжгүй 43 нэр төрлийн эмийн үнэнд өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлсэн. Мөн Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 485 дугаар албан бичгээр эмийн сангуудад ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн үнийн дээд хязгаарын

дүнг иргэдэд олгож байгаа эмийн баримтын дүнг зөрүүгүй олгож байхыг зөвлөв.

Шийдвэрлэсэн байдал:

2020 оны IV улирлын байдлаар Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэгт иргэд, ажилчдаас гаргасан нийт 44 өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авч, хуулийн хугацаанд 41 буюу 93,1%-тай шийдвэрлэж хариуг эзэд нь хүргүүлсэн байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭМГ-ЫН УТСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

ХЯНАСАН:

ЭМГ-ЫН ДАРГА



A handwritten signature in black ink, likely belonging to S. OLSHIYBAYAR, positioned to the right of the stamp.

С.ӨЛЗИЙБАЯР

Г.БАТ-ОРШИХ

Хүснэгт 1

2020 ОНЫ IV УЛИРЛЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2020.12.23

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт					Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	Хугацаа	
1	Эрүүл мэндийн газар	13	10	0	0	3	76.9%	
2	Нэгдсэн эмнэлэг	31	31	0	0	0	100%	
	НИЙТ ДҮН	44	41	0	0	3	93.1%	

Хүснэгт 2

2020 ОНЫ IV УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ХЭЛБЭРЭЭР

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдол санал хүсэлт	Үүнээс					Бусад
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад	
1	Эрүүл мэндийн газар	13	11	0	2	0	0	
2	Нэгдсэн эмнэлэг	31	31	0	0	0	0	
	НИЙТ ДҮН	44	42	0	2	0	0	

Хүснэгт 3

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА ХУВИАР

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал (тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь)			
1	Дундговь аймаг	Өргөдөл	44		
		Хүсэлт	39		
		Санал	0		
		Гомдол	5		
		Талархал			
		Асуудлын нэр		Нийт тоо	Нийт хувь
		Хөдөлмөрийн зохион байгуулалт хийлгэж чөлөө хүссэн		22	50%
		Ажилд орохыг хүссэн		5	11.3%
		Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой		5	11.3%
		Ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн		5	11.3%
		Мэргэжлийн үйл ажиллагаа сунгуулах		1	2.7%
Тэтгэмжтэй холбоотой		1	2.7%		
Түрээстэй холбоотой		1	2.7%		
Ахмад ажилчид түлшний мөнгө хүссэн		3	6.8%		

Хүснэгт 4

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ГАРГАСАН САНАЛ-ЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ТУСГАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	Саналын агуулга	Хэрэгжилт	Хувь
1				
2				
3				

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР